



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/382

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 2.1.4, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын 4 дүгээр багт байршилтай Хэрлэн лаборатори 1 дүгээр сургуулийн барилгыг буулгасантай холбогдуулан “Нямодо трейд” ХХК-аас ирүүлсэн дулаан түгээх үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тухай албан хүсэлтэд дүгнэлт гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажлын хэсгийн гишүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	С.Лхагвачулуун	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Б.Гантөгс	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтэсийн дарга
	Т.Жанчив	Мэргэжлийн хяналтын газрын Харилцаа холбоо, эрчим хүчний хяналтын улсын байцаагч
	Б.Гантөмөр	"Хэнтий-Ус" ХХК-ийн ерөнхий инженер
	Б.Мөнх-Эрдэнэ	Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн
	Н.Дархан-Очир	"Нямодо трейд" ХХК-ийн захирал